

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/001/НА-СТА-ТЕЗ

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: Khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: Amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Адъяасүрэн

Утас: 702723204 Цахим хаяг: Adiyasurenb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: Khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын илрүүлэлт	13
3.2.3 Албан шаардлага	13
3.2.4 Зөвлөмж.....	16
4. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БНСБС	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.04.20 № 01/398
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч, 65 төсөвт байгууллага, 103 тусгай зориулалттай сан, 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, нийт 205 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн VIII дугаар хуралдааны "Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт дүгнэх тухай" 02 дугаар тогтоолоор 8 бодлогын 173 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг 92,25 хувийн гүйцэтгэлтэй буюу "Үр дүн гарсан", "Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэх тухай" 05 дугаар тогтоолоор 4 бодлогын зорилт, 227 арга хэмжээний хэрэгжилтийг 88,06 хувийн гүйцэтгэлтэй буюу "Үр дүн гарсан" гэж дүгнэсэн байна. Мөн "Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт дүгнэх тухай" 06 дугаар тогтоолоор 8 бодлогын, 129 төсөл, арга хэмжээ 86,54 хувийн гүйцэтгэлтэй "Үр дүн гарсан" гэж тус тус дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус I дүгээр хуралдааны 17 дугаар тогтоолоор улсын төсвөөс 2,154.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар баталсан бол 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн V дугаар хуралдааны 26 дугаар тогтоолоор улсын төсөвт 2,370.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тодотгон баталж бүрэн төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,133.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 8 байгууллага “хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын алдаа зөрчлийг нэгтгэн дүгнэхэд дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодоогүй, бараа материалыг акталж данснаас хасахдаа өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцсон, татварын болон татварын бус орлогыг нэр төрлөөр бүрэн биелүүлээгүй, анхан шатны баримтын иж бүрдэл хангагдаагүй ажил гүйлгээг бүртгэсэн, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангаар авлага үүсгэсэн боловч, санхүүгийн тайланд тусгаагүй, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй, Монгол банкны мэдээллийн санд зээлийн үлдэгдлийн мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн, худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй, зардлын эдийн засгийн ангиллыг зөрчин зарцуулсан нь нийт зөрчлийн 77,2 хувийг эзэлж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой байршуулбал зохих мэдээллийг тогтсон хугацаанд, тогтмол, үнэн зөв мэдээлээгүй зөрчил нь нийт зөрчлийн 22,8 хувийг эзэлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		90,967,952.92	116,289,330.15
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	52,892,396.36	79,307,546.35
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	26,534,897.52	24,368,792.76
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	24,012.59	37,771.06
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	11,476,716.14	12,443,402.23
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	39,930.32	131,817.74
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		174,533,262.87	236,459,438.37
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	174,533,262.87	236,459,438.37
9	1.2.2.02 Биет хөрөнгө		147,927,812.41	183,194,296.08
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	26,599,860.46	53,260,103.13
11	1.2.2.04 Бусад хөрөнгө / ТӨҮГ/	14	5,590	5,039.15
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		265,501,215.79	352,748,768.52
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,131,324.73	11,892,289.63
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,257,638.73	11,123,803.63
15	2.1.1.03 Өглөг		4,047,802.63	10,971,181.53
16	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	209,836.11	152,622.11
17	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		873,686	768,486
18	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	873,686	768,486
19	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		260,369,891.06	340,856,478.88
20	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		260,369,891.06	340,856,478.88
21	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		32,806,806.78	32,806,806.78
22	2.2.1.02 Өмч / төрийн/ / ТӨҮГ/		813,405.35	930,372.35
23	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг / ТӨҮГ/		10,587,991.99	11,297,220.1
24	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		200,455,761.67	280,633,435.47
25	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,705,925.27	15,188,644.19
26	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		265,501,215.79	352,748,768.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		211,627,927.49	219,747,500.48
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		82,091,630.17	102,895,137.28
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		54,499,538.4	75,953,196.76
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		42,644,218.32	52,536,679.25
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,375,642.85	-1,654,265.26
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		13,230,962.93	25,070,782.77

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		14, 199, 350.94	13, 484, 998.62
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		13, 392, 740.82	13, 456, 941.89
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	94, 849, 405.94	116, 852, 363.2
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого		647, 431.92	87, 487.97
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		1, 788, 162.41	1, 386, 708.56
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		34, 686, 891.39	0.0
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	129, 349, 678.08	123, 614, 108.77
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		109, 941, 729.08	117, 009, 773.5
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		107, 060, 591.32	111, 089, 622.22
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		31, 252, 820.98	40, 155, 642.79
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3, 933, 432.48	4, 932, 640.44
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		24, 310, 291.11	28, 682, 177.87
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2, 810, 208.24	2, 328, 374.75
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		2, 327, 576.98	2, 361, 591.99
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		1, 337, 107.92	1, 479, 049.43
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		465, 313.93	449, 321.7
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4, 672, 557.47	5, 918, 939.68
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		35, 951, 282.2	24, 781, 883.57
25	1.1.2.01.2 ХҮҮ		125, 714	123, 610
26	1.1.2.01.3 ТАТААС		198, 162	41, 543.6
27	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2, 557, 261.76	5, 754, 997.67
28	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		19, 407, 949	6, 604, 335.27
29	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)		82, 278, 249.42	96, 133, 391.71
30	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		166	6, 842.47
31	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		21, 440, 245.26	14, 623, 117.6
32	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)- (V)		-21, 440, 079.26	-14, 616, 275.13
33	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		60, 838, 170.16	81, 517, 116.58

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	170, 636, 418.63	162, 962, 724.5
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	82, 227, 203.31	102, 896, 669.28
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	54, 635, 111.54	75, 953, 196.76
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1, 375, 642.85	-1, 654, 265.26
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	13, 230, 962.93	25, 070, 782.77
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	14, 199, 350.94	13, 486, 530.62
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	13, 392, 740.82	13, 456, 941.89
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	4, 985, 998.62	4, 191, 265.92
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	3, 704, 276.26	5, 327, 430
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	4, 702, 465.94	3, 938, 245.97
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55, 440, 047.82	60, 066, 055.22
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	36, 181, 518.27	33, 787, 671.19
13	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	647, 431.92	87, 487.97
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	1, 770, 491.63	1, 370, 863.06
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	16, 840, 606	24, 820, 033
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32, 969, 167.5	0.0
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97, 592, 010.48	104, 785, 176.31
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	97, 592, 010.48	104, 785, 176.31
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94, 739, 039.91	97, 820, 165.49
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31, 104, 348.42	38, 308, 503.4
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4, 971, 151.76	4, 981, 751
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25, 902, 915.57	28, 080, 513.66
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	4, 170, 717.59	3, 293, 393.34
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	2, 329, 518.66	2, 656, 143.27
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1, 673, 666.12	2, 503, 354.6
26	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	463, 858.7	371, 079.8
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4, 156, 518.17	5, 630, 796.58
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	19, 966, 344.91	11, 994, 629.84
29	1.1.1.2.01.2 ХҮҮ	125, 714	18, 410
30	1.1.1.2.01.3 ТАТААС	198, 162	41, 543.6
31	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2, 529, 094.58	6, 905, 057.21
32	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)- (II)	73, 044, 408.15	58, 177, 548.19
33	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	54, 542, 709.05	29, 621, 011.41
34	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54, 542, 709.05	29, 621, 011.41
35	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	54, 542, 709.05	29, 621, 011.41
36	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)- (V)	-54, 542, 709.05	-29, 621, 011.41

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

37	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2, 946, 944.55	1, 829, 651.99
38	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	355, 764.8
39	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2, 946, 944.55	-2, 185, 416.79
40	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15, 554, 754.54	26, 371, 119.99
41	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37, 337, 641.82	52, 892, 396.36
42	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52, 892, 396.36	79, 263, 516.35

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	195, 713, 503.95		195, 713, 503.95
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3, 940, 496.92		3, 940, 496.92
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	199, 654, 000.86		199, 654, 000.86
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-975, 170.27		-975, 170.27
5	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	852, 890.3		852, 890.3
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	60, 838, 170.16		60, 838, 170.16
7	1.1.1.1 2024 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	260, 369, 891.06		260, 369, 891.06
8	1.1.1 2025 оны 1- р сарын 1- нээрх үлдэгдэл	260, 369, 891.06		260, 369, 891.06
9	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1, 374, 884.88		-1, 374, 884.88
10	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258, 995, 006.17		258, 995, 006.17
11	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-485, 131.12		-485, 131.12
12	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-32, 149.95		-32, 149.95
13	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	861, 637.2		861, 637.2
14	1.7 Тайлант үеийн үр дүн	81, 517, 116.58		81, 517, 116.58
15	1 2025 оны 12- р сарын 31- наарх үлдэгдэл оны 12- р сарын 31- наарх үлдэгдэл	340, 856, 478.88		340, 856, 478.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12- р сарын 31	2025 оны 12- р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	298,904,594.9	311,954,749.8
2	3.1.01.1.1 Татварын орлого	85,685,301.0	102,896,669.3
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	58,668,522.7	75,953,196.8
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	45,322,788.0	52,536,679.3

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

5	3.1.01.1.1.1.1.01	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	39,032,788.0	43,438,194.6
6	3.1.01.1.1.1.1.02	Үйл ажиллагааны орлого	1,250,000.0	1,937,486.3
7	3.1.01.1.1.1.1.03	Хөрөнгийн орлого	3,520,000.0	2,670,164.3
8	3.1.01.1.1.1.1.04	Хөрөнгө борлуулсны орлого	840,000.0	1,507,135.5
9	3.1.01.1.1.1.1.06	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	680,000.0	2,983,698.5
10	3.1.01.1.1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,654,265.3)	(1,654,265.3)
11	3.1.01.1.1.1.2.01	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,654,265.3)	(1,654,265.3)
12	3.1.01.1.1.1.4	ААН-ын орлогын албан татвар	15,000,000.0	25,070,782.8
13	3.1.01.1.1.1.4.01	ААН-ын орлогын албан татвар	15,000,000.0	25,070,782.8
14	3.1.01.1.1.3	Хөрөнгийн албан татвар	13,417,569.2	13,486,530.6
15	3.1.01.1.1.3.1	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	11,359,847.9	11,077,098.1
16	3.1.01.1.1.3.2	Бууны албан татвар	33,000.0	34,071.6
17	3.1.01.1.1.3.3	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	670,000.0	744,700.1
18	3.1.01.1.1.3.4	Малд ногдуулах албан татвар	1,354,721.3	1,630,660.9
19	3.1.01.1.1.8	Бусад татвар, төлбөр, хураамж	13,599,209.1	13,456,941.9
20	3.1.01.1.1.8.1	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,794,100.0	4,191,265.9
21	3.1.01.1.1.8.1.01	Улсын тэмдэгтийн хураамж	3,281,000.0	3,563,548.1
22	3.1.01.1.1.8.1.02	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	16,729.7
23	3.1.01.1.1.8.1.06	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	120,000.0	161,061.9
24	3.1.01.1.1.8.1.07	Ус бохирдуулсны төлбөр	-	360.0
25	3.1.01.1.1.8.1.08	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	390,100.0	449,566.3
26	3.1.01.1.1.8.1.09	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	3,000.0	-
27	3.1.01.1.1.8.2	Газрын төлбөр	3,890,790.8	5,327,430.0
28	3.1.01.1.1.8.2.01	Газрын төлбөр	3,836,616.7	5,313,340.1
29	3.1.01.1.1.8.2.02	Дуудлага худалдаа	54,174.1	14,089.9
30	3.1.01.1.1.8.3	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,914,318.3	3,938,246.0
31	3.1.01.1.1.8.3.01	Ойн нөөц ашигласны төлбөр	1,732,544.4	325,724.9
32	3.1.01.1.1.8.3.02	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,942,373.9	1,382,592.5
33	3.1.01.1.1.8.3.03	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2,239,400.0	2,229,308.5
34	3.1.01.1.1.8.3.04	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	-	620.1
35	3.1.01.1.2	Татварын бус орлого	213,219,293.9	209,058,080.5

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

36	3.1.01.1.2.1	Нийтлэг татварын бус орлого	10,095,140.8	13,268,652.1
37	3.1.01.1.2.1.3	Торгуулийн орлого	4,758,774.2	7,047,001.7
38	3.1.01.1.2.1.4	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,511,166.6	2,617,699.6
39	3.1.01.1.2.1.5	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	66,284.7
40	3.1.01.1.2.1.6	Түрээсийн орлого	104,700.0	300,421.8
41	3.1.01.1.2.1.9	Бусад орлого	720,500.0	3,237,244.3
42	3.1.01.1.2.2	Хөрөнгийн орлого	100,000.0	87,488.0
43	3.1.01.1.2.2.1	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	100,000.0	87,488.0
44	3.1.01.1.2.3	Тусламжийн орлого	178,036,634.1	170,881,907.4
45	3.1.01.1.2.3.2	Хандив тусламж /гадаад/	300,000.0	104,245.0
46	3.1.01.1.2.3.3	Аймаг нийслэлээс авсан татаас	16,853,494.4	16,853,494.4
47	3.1.01.1.2.3.4	Сум дүүргээс авсан тэгшитгэл	25,736,824.9	25,736,825.0
48	3.1.01.1.2.3.5	Төсвөөс санхүүжих	135,146,314.8	128,187,343.0
49	3.1.01.1.2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	24,987,519.0	24,820,033.0
50	3.1.01.1.2.4.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	24,987,519.0	24,820,033.0
51	3.1.01.2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	204,516,710.1	153,878,760.3
52	3.1.01.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	136,471,380.1	124,091,771.1
53	3.1.01.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,730,196.7	70,563,276.1
54	3.1.01.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,340,931.4	29,364,522.1
55	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	16,861,226.0	16,460,672.3
56	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	11,030,794.7	10,561,353.4
57	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	1,112,136.8	1,061,119.7
58	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	856,696.3	827,935.9
59	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	480,077.6	453,440.8
60	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,816,947.7	3,659,166.8
61	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	2,601,274.4	2,502,671.0
62	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	304,060.5	294,101.1
63	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	153,579.9	148,680.3
64	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	151,405.6	141,636.0
65	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	606,627.3	572,078.2
66	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,184,095.3	22,249,503.1
67	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	2,977,877.4	2,729,066.3
68	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	19,386,922.1	18,759,609.5
69	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	818,152.8	759,979.6
70	3.1.01.2.1.1.3.04	Байрны түрээс	1,143.0	847.6
71	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	1,623,689.9	1,188,748.5
72	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	216,006.4	154,451.0
73	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	978,571.2	713,212.7
74	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	176,169.9	138,892.6

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

75	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,030.0	153,034.0
76	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,912.4	29,158.2
77	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	296,230.2	253,023.4
78	3.1.01.2.1.1.5.01	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	197,795.0	197,794.2
79	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	98,435.2	55,229.2
80	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	3,307,392.7	2,584,795.6
81	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	718,409.8	510,232.7
82	3.1.01.2.1.1.6.02	Тавилга	57,818.3	22,650.0
83	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	2,531,164.6	2,051,913.0
84	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	507,456.4	367,619.8
85	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	507,456.4	367,619.8
86	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,483,034.2	4,585,396.0
87	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,202,543.2	4,420,580.8
88	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	65,510.4	19,637.8
89	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	27,914.4	14,088.5
90	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	31,613.5	13,573.3
91	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,466.4	6,997.5
92	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,308.0	15,966.7
93	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	121,678.3	94,551.5
94	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	11,170,418.9	6,250,547.1
95	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	10,893,189.5	6,087,040.8
96	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	277,229.4	163,506.3
97	3.1.01.2.1.2	ХҮҮ	18,410.0	18,410.0
98	3.1.01.2.1.2.2	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	18,410.0	18,410.0
99	3.1.01.2.1.2.2.01	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	18,410.0	18,410.0
100	3.1.01.2.1.3	ТАТААС	82,000.0	41,543.6
101	3.1.01.2.1.3.2	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	82,000.0	41,543.6
102	3.1.01.2.1.3.2.01	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	82,000.0	41,543.6
103	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,640,773.4	53,528,495.1
104	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	53,149,273.8	51,493,076.5
105	3.1.01.2.1.4.1.01	Засгийн газрын дотоод шилжүүлэг	53,149,273.8	51,493,076.5
106	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	2,491,499.6	2,035,418.6
107	3.1.01.2.1.4.2.02	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	147,679.2	78,948.4

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

108	3.1.01.2.1.4.2.03	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	124,305.0	36,232.0
109	3.1.01.2.1.4.2.04	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,201,555.3	1,105,280.4
110	3.1.01.2.1.4.2.06	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	640,668.2	572,248.6
111	3.1.01.2.1.4.2.07	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	202,527.9	184,449.3
112	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	174,764.0	58,259.9
113	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,871,941.5	27,957,337.2
114	3.1.01.2.2.1	Барилга байгууламж	19,726,458.9	7,126,968.9
115	3.1.01.2.2.2	Их засвар	17,286,172.2	10,741,440.4
116	3.1.01.2.2.3	Тоног төхөөрөмж	2,626,244.5	1,061,887.9
117	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	24,233,065.9	9,027,040.0
118	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,173,388.5	1,829,652.0
119	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	4,173,388.5	1,829,652.0
120	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	94,387,884.8	19,983,328.5
121	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(94,387,884.8)	(19,983,328.5)
122	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(94,387,884.8)	(19,983,328.5)
123	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	46,028,165.3
124	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	75,172,709.7
125	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,277	2,206
126	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	64	64
127	6.1.01	Төсвийн байгууллага	64	64
128	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,101	1,066
129	6.2.01	Удирдах ажилтан	253	249
130	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	582	553
131	6.2.03	Үйлчлэх ажилтан	233	236
132	6.2.04	Гэрээт ажилтан	33	28
133	6.5	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,101	1,066
134	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	449	432
135	6.5.02	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
136	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	400	383
137	6.5.10	Гэрээт ажилтан	65	63
138	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	183	184
139	6.6	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	11	10
140	6.6.01	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	11	10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	17,023,032.60	8,544,877.74
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,023,032.60	8,544,877.74
12213	1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	17,023,032.60	8,544,877.74

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,990,556.60	7,872,210.38
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	12,210,284.90	5,321,059.99
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,072,613.20	5,262,640.29
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,003,718.60	3,710,575.90
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	353,789.70	449,922.37
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,048.10	12,374.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	237,841.40	91,477.86
2105	1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	-	22,321.84
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	86,792.90	216,827.67
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	35,461.50	500.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,351.20	26,787.90
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	5,255,609.80	731,852.75
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,137,671.70	58,419.70
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,592,010.40	58,419.70
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,780,271.70	2,551,150.39
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	4,780,271.70	2,551,150.39
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	672,667.36

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,514.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 142.7 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

3.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2.3 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант онд нийт 290.4 сая төгрөгийн нөөцийн өвс худалдаж авсан боловч холбогдох байгууллагын дансанд орлого авч бүртгээгүй, өвсний орлого, зарлагын тооцоо байхгүй, борлуулалтын орлогыг хаана тушаасан нь тодорхойгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Баяр наадмын "Үдшийн цэнгүүн-д 18.0 сая төгрөг, "Мөнгөн үдэш-2025" шинэ жилийн арга хэмжээнд 24.7 сая төгрөг, нийт 42.7 сая төгрөгийг зарцуулж төсвийг үр ашиггүй

зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Эмийн эргэлтийн сангийн авлагын үлдэгдэл 435.6 сая төгрөг болж өмнөх оноос 45.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ авлага нь эмийн санч болон, ажиллагсадтай холбоотойгоор үүссэн авлага бөгөөд эмийн эргэлтийн сангаас борлуулсан эмийн үнийг цаг тухай бүрд нь тушаадаггүй, эмийн дутагдал гаргасан, зээлээр иргэдэд эм олгосон зэргээс үүссэн байна. Мөн өмнөх оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 12 дугаар зүйлийн 12.2.2-д “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Тайлант онд 10 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс Заамарын хөгжил ОНӨААТҮГ, Сэргэлэн нутгийн хөгжил ОНӨААТҮГ, Эрдэнэ тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Баруун Зуунмод ӨЭМТ алдагдалтай ажилласан, Эко төв Жаргалант ОНӨААТҮГ байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй, Төв Эрдэнэс ОНӨААТҮГ, Шимт бордоо органик ХХК үйл ажиллагаа явуулаагүй байна. Мөн өмнөх оны ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д “Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 21.2-д “Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана”, 21.2.4-д “санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг”, 77 дугаар зүйлийн 77.2.4-д “орон нутгийн өмчийн хуулийн

этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 05/130 дугаартай албан бичгээр Мал хамгаалах сан нь 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй хэмээн санхүүгийн тайлан ирүүлээгүй. Гэвч тайлант онд аймгийн Мал хамгаалах сан нь 11.6 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж, 34.8 сая төгрөгийн бараа материалыг бусад байгууллагад шилжүүлэн тус тус гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Тайлант оны 6 дугаар сарын 23-ны өдрийн аймгийн Засаг даргын А/338 дугаар захирамжаар төсвөөс рийл, контент бичлэгийн төлбөрт 2.5 сая төгрөгийг зарцуулснаас "Монгол-2000" төгсөгчдийн спортын олон төрөлт тэмцээний шууд дамжуулалтад 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт 1: Төсвөөс гарын бэлэг, дурсгалын зүйлд 75.8 сая төгрөг, спортын тэмцээн уралдаан зохион байгуулахад 2.4 сая төгрөг, хоолны зардалд өмнөх оноос 50,8 хувиар их буюу 108.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийн үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт 2: Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсөв 1,800.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 1,554.5 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 73.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувь буюу 540.0 сая төгрөгийг нөөцөд байршуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.4-т “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг баримталж ажиллах

Илрүүлэлт 3: Урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжтой, хөрөнгө оруулалтын шинжтэй 8 ажилд 178.1 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалт бусаар санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5-д “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”, 3.1.2-т “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Урьдчилан төлөвлөх боломжтой, хөрөнгө оруулалтын ажлуудыг төсөвт суулган батлуулж худалдан авах журмын дагуу зарцуулах

Илрүүлэлт 4: Алтан намар арга хэмжээнд 29.2 сая төгрөг, Мөнгөн үдэш арга хэмжээнд 24.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Тус арга хэмжээнүүдийг жил бүр зохион байгуулагддаг тул ЗДТГ-ын төсөвт суулгаж зарцуулалгүй Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулж хэвшсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5-д “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тус арга хэмжээнүүдийн зардлыг төсөвтөө суулгаж аймгийн ЗДТГ-ын данснаас зарцуулах

Илрүүлэлт 5: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тогтмол мэдээлэх 157 мэдээллээс хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 46 мэдээлэл, нийт мэдээлсэн байдлын хэрэгжилт 100,0 хувьтай, хугацаа хоцролтын хэрэгжилт 80,5 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ", 8.2-д "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ", 8.4-д "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулж байх.

Илрүүлэлт 6: Аймгийн Ахмадын хороо нь бие даасан үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон, улсын бүртгэлийн гэрчилгээтэй, татвар, нийгмийн даатгал болон төрийн өмчийн программд тусдаа байгууллага байдлаар тайлагнадаг байна. Гэвч Засгийн газрын санхүүгийн тайлангийн *finperform* цахим системд Засаг даргын ерөнхий дансанд тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-д "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-д "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг" гэж заасантай тохирохгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын хорооны тайланг Засаг даргын ерөнхий данснаас салгаж тусад эрхээр бие дааж тайлагнах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЛДААНЫ НЭГТГЭЛ

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
ТЕЗ	0	-					0	-			
ТТЗ	16	1,158.2	4	516.5	12	641.7	16	1,158.2			
ТШЗ	99	21,699.0	26	1,091.7	73	20,607.3	99	21,699.0			
ОНӨГ	5	4,339.4	3	4,319.9	2	19.5	5	4,339.4			
ОНТС	43	1,199.4	23	686.1	20	513.3	43	1,199.4			
Дүн	163	28,396.1	56	6,614.2	107	21,781.9	163	28,396.1	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн
ТЕЗ	11	1,514.9			6	425.9	5	1,089.0			
ТГТ	0	-									
ТТЗ	40	5,007.6			10	1,510.2	29	3,497.4	1	1	
ТШЗ	171	2,739.9	42	66.8	52	988.0	76	1,685.1	1	1	
ОНӨГ	11	4,477.9	1	0.7	2	6.1	8	4,471.1			
ОНТС	62	2,529.8	9	63.4	20	1,308.8	31	1,143.9	2	3	13.7
Дүн	295	16,270.1	52	130.9	90	4,238.9	149	11,886.5	4	5	13.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТЕЗ	1	-					1	
ТТЗ	19	-			6		13	
ТШЗ	36	3,573.7			11	1,311.6	25	2,262.1
ОНӨГ	3	-					3	
ОНТС	15	804.8			2	778.4	13	26.5
Дүн	74	4,378.5	0	0	19	2,090.0	55	2,288.5
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТГТ	2	15,807.2					2	15,807.2
ТТЗ	1	-					1	
ТШЗ								
Дүн	3	15,807.2	-	-	-	-	3	15,807.2
Нийт дүн	77	20,185.7	-	-	19	2,090.0	58	18,095.7